



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам, заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам", 2012 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам", "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай" Хорооны 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 82 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тогтоолоор батлагдсан журам, зааврыг нэг мөр ойлгож хэрэглэх, програмд оруулах, турших, шалгах, мөрдүүлж хэвшүүлэх чиглэлээр ажиллагсад болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоогоор дамжуулан Хадгаламж, зээлийн хоршоодод сургалт зохион байгуулах, сурталчлах, зөв ойлгуулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/, Хяналт, шалгалтын газар /Б.Оюунцацрал/, Бичил санхүүгийн зохицуулалтын газар /Н.Оюунчимэг/, Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5. Журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001097



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос Хадгаламж, зээлийн хоршоо /цаашид "ХЗХ" гэх/-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд хийх зохицуулалтын шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэхдээ Хорооноос баталсан зааврыг мөрдөнө.

1.3. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргаж ирүүлэх баримт бичигт тавигдах шаардлага, бүрдүүлэх, баримт бичгийг хүлээн авах, хянах зааврыг Хорооны тогтоолоор батална.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "хадгаламж" гэж мөнгөн хадгаламжийн бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр зөвхөн ХЗХ-ны гишүүдээс хоршоонд хадгалуулсан мөнгөн хөрөнгийг;

2.1.2. "зээл" гэж тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа, эсхүл батлан даалттай зээлийн гэрээний дагуу гишүүндээ зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийг;

2.1.3. “санхүүгийн бусад ажил, үйлчилгээ” гэж Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т заасны дагуу ХЗХ-оос гишүүддээ үзүүлж болох энэхүү журмын 3.4.1-д заасан ажил, үйлчилгээг;

2.1.4. “санхүүгийн түрээсийн үйлчилгээ” гэж тоног төхөөрөмж, техник хэрэгслийг гуравдагч этгээдээс худалдан авч, гишүүддээ тодорхой нөхцөлтэйгээр түрээслүүлж, түрээсийн төлбөрийг санхүүжүүлж, түрээсийн хугацаа дуусгавар болоход гишүүн ХЗХ-нд санхүүжилтыг буцаан төлж дууссан тохиолдолд түрээсийн эд зүйлийг гишүүний өмчлөлд шилжүүлэх үйлчилгээг;

2.1.5. “төслийн санхүүжилт” гэж хоршооны гишүүдийн хэрэгцээг хангах зорилгоор бичил бизнес, орон нутгийн хөгжлийг дэмжих зориулалт бүхий гуравдагч этгээдтэй хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд, эсхүл өөрийн эх үүсвэрээр гишүүний хэрэгжүүлэх бичил, жижиг бизнесийн төслийг санхүүжүүлэх, зээл олгох үйлчилгээг;

2.1.6. “цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гишүүдийнхээ бэлэн мөнгийг цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан цахим мөнгөн хэлбэрт хөрвүүлэх, цахим хэтэвч эзэмшигч гишүүдийн бүртгэл болон бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээг;

2.1.7. "даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа" гэж даатгагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гишүүддээ даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах үйл ажиллагааг;

2.1.8. "мөнгөн гуйвуулгын үйлчилгээ" гэж гишүүдийнхээ мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагааг;

2.1.9. "хуримтлалын сан үүсгэх, удирдах" гэж гишүүдийнхээ нэр дээр нэгж эрх нээж, тэдгээрийн зөвшөөрснөөр дундын хуримтлалын сан үүсгэн ирээдүйд хэрэглэх хуримтлал үүсгэх, тэтгэвэр, тэтгэмжийн эх үүсвэрийг бий болгож, түүнийг үр ашигтай байдлаар хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр удирдах ажиллагааг.

ГУРАВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. ХЗХ нь дараах нийтлэг шаардлагыг хангаж ажиллана:

3.1.1. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

3.1.2. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлах;

3.1.3. бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гүйцэтгэх захирал нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиар олгосон гишүүдийн бүрэн эрхийг хангаж, тэдний эрх ашгийн төлөө ажиллах;

3.1.4. Хорооноос тогтоосон ХЗХ-ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллах;

3.1.5. ХЗХ-ны актив хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 145/124 дүгээр тушаалаар батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулах;

3.1.6. нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хөтлөж, жилийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулах;

3.1.7. санхүүгийн болон зохистой харьцааны тайлан, статистик мэдээ, мэдээллийг тогтоосон маягтын дагуу хугацаанд нь гаргаж Хороонд хүргүүлэх;

3.1.8. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төвлөрүүлж байх;

3.1.9. ажлын байр, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн програм хангамж нь тухайн ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл шаардлага хангасан байх;

3.1.10. тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гүйцэтгэх захирал нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4, 34.11-г заасан шаардлагыг хангасан байна.

3.2. Хадгаламжийн үйл ажиллагаа:

3.2.1. Хадгаламжийн үйл ажиллагааг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 16 дугаар зүйл, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар бүлгийг мөрдлөг болгох;

3.2.2. хадгаламжийн төрлийг тодорхойлохдоо гадаад, дотоод орчин, макро эдийн засгийн тэнцвэртэй байдал, санхүүгийн зах зээлийн эрсдлийн түвшинг үнэлсэн судалгаанд суурилсан шийдвэр гаргах;

3.2.3. хадгаламжийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж мөрдөж ажиллах;

3.2.4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу гишүүдийн хадгаламжийг даатгах, эсхүл хамгаалалтын болон тогтворжуулалтын санг байгуулах;

3.2.5. хадгаламжийн хүүг тогтоохдоо үйл ажиллагааны орлого, зардал, өгөөж, эрсдэлийг тооцож, салбарын болон тухайн орон нутгийнхаа зах зээлийн дундаж хүүг харгалзана.

3.3. Зээлийн үйл ажиллагаа:

3.3.1. Зээлийн үйл ажиллагааг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 17 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу эрхлэх;

3.3.2. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-г заасны дагуу Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулж ажиллах;

3.3.3. зээлийн хүүгийн хувь хэмжээг тогтоохдоо үйл ажиллагааны орлого, зардал, цэвэр орлогыг тооцож, салбарын болон тухайн орон нутгийнхаа зах зээлийн дундаж хүүг харгалзаж үзэх;

3.3.4. гишүүний зээлийн төлбөрт түүний хадгаламжаас шууд суутгахгүй зөвхөн өөрийнх нь хүсэлт, шүүхийн шийдвэрийг үндэслэн зарлагын гүйлгээ хийх;

3.3.5. зээлийн талаар баримтлах бодлогоо боловсруулж, тухайн үеийн байдал, хэтийн төлөвийг судлаж, эрсдлийг тооцож ажиллана.

3.4. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ

3.4.1. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээнд энэ журмын 2.1.4-2.1.9-д заасан ажил, үйлчилгээ хамаарна.

3.4.2. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн түрээсийн /лизингийн/ тухай хууль, Хорооноос батлагдсан холбогдох бусад журам, заавар, энэхүү журмыг мөрдөж ажиллана.

3.4.3. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа:

3.4.3.а. Тухайн ХЗХ-ны гишүүдээс бусад этгээдэд даатгалын гэрээ борлуулахгүй байх;

3.4.3.б. даатгагчаас олгосон даатгалын төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөлтэй байх;

3.4.3.в. ХЗХ-г төлөөлж даатгалын гэрээ борлуулах хоршооны гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын орон тооны албан тушаалтан нь даатгалын сургалтад хамрагдаж, даатгалын төлөөлөгчийн шалгалтад тэнцсэн байна.

3.4.4. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ:

3.4.4.а. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэхдээ Иргэний хуулийн 26 дугаар бүлэг, Санхүүгийн түрээсийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллах;

3.4.4.б. Санхүүгийн түрээсээр авч байсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь даатгуулсан, эсхүл Зээлийн батлан даалтын сангаар баталгаа гаргуулсан байна.

3.4.5. Төслийн санхүүжилт:

3.4.5.а. Төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэхэд тавигдсан нөхцөл, шаардлагыг хангасан байх;

3.4.5.б. дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах, хангуулах;

3.4.5.в. зээлдэгч бүрт хувийн хэрэг нээж, хөтлөх;

3.4.5.г. дамжуулан зээлдүүлэх гэрээ, төслийн гэрээнд заасан хуваарийн дагуу зээлдүүлсэн зээлийн хүүгийн болон үндсэн төлбөрийг хугацаанд нь төлнө.

3.4.6. Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ:

3.4.6.а. Үйлчилгээний журамд Хорооны 2011 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”-ын 5.5, 5.6-г заасан эрх, үүргийг тодорхой тусгах;

3.4.6.б. ажлын байрандаа цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс олгосон таних тэмдэг бүхий батламж, дансны дугаар, үйлчилгээний үнийн саналыг гишүүдэд харагдахуйц газар байрлуулна.

3.4.7. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ:

3.4.7.а. ХЗХ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлийг боловсруулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, програм хангамж зэрэг мэдээллийн технологийн асуудлаа шийдвэрлэсэн байна.

3.4.8. Хуримтлалын сан үүсгэх, удирдах үйл ажиллагаа:

3.4.8.а. Сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах журам, сангийн дүрмийг бүх гишүүдийн хурлаар батлаж, мөрдөх;

3.4.8.б. хуримтлагдсан хөрөнгийг өсгөж, үр ашигтай удирдах хөрөнгө оруулалтын мэргэжилтэнтэй байх;

3.4.8.в. хуримтлалын сан нь сайн дурын гишүүнчлэлтэй байх;

3.4.8.г. сангийн хөрөнгийн эх үүсвэр нь ХЗХ-ны бүх гишүүдийн хурлаар баталсан хэмжээгээр сар бүрийн гишүүдийн хураамж, сайн дурын хандив /төрийн ба төрийн бус байгууллага, иргэд, ААН, Олон улсын байгууллага/, ХЗХ-оос тус санд зөвхөн тухайн жилийн цэвэр орлогоос ХЗХ-ны дүрэмд заасан хэмжээгээр нөөцийн санг бүрдүүлсний дараа тодорхой хувийг бүх гишүүдийн хурлын шийдвэрээр хуваарилж болох, хуулинд хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдүүлэх;

3.4.8.д. сангийн хөрөнгийг тусгаарласан дансанд төвлөрүүлсэн байх;

3.4.8.е. санд хураамж төлж, хуримтлал үүсгэсэн гишүүн нас барсан тохиолдолд уг сангаас түүнд ногдох мөнгөн хөрөнгийг өвлүүлэх боломжтой байх;

3.4.8.ё. санд орлого хуримтлуулах болон сангийн хөрөнгийг зарцуулах бодлого нь тодорхой, гишүүдэд ил тод тайлагнадаг байх.

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

4.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн ХЗХ нь дараах нөхцөл шаардлагыг хангасан байна:

4.1.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасны дагуу үүсгэн байгуулагдсан байх;

4.1.2. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3-г заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

4.2. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх, салбар байгуулах, оноосон нэр өөрчлөх, өөрчлөн байгуулахыг хүссэн ХЗХ нь дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:

4.2.1. Тухайн зөвшөөрөлтэй холбогдох асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн байх;

4.2.2. тухайн зөвшөөрөлтэй холбогдолтой зохицуулалтыг дүрмэнд тусгасан байх;

4.2.3. тухайн зөвшөөрөл нь ХЗХ-ны санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, гишүүдэд нь хохирол учруулахгүй байх;

4.2.4. тухайн зөвшөөрөл авах ажил, үйлчилгээнд мөрдөх журам, заавар нь Монгол Улсын Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, тухайн ажил, үйлчилгээтэй холбоотой бусад хууль, тогтоомж, Хорооноос гаргасан заавар, журмын хүрээнд боловсруулж батлагдсан болон гишүүдийн эрх ашгийг хангахад чиглэгдсэн байх;

4.2.5. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 17/16 дугаар тогтоолоор батлагдсан "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс бусад санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүсэгч ХЗХ нь 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, сүүлийн 4 улирал дараалан ашигтай ажилласан байна.

4.2.6. Хорооноос хийсэн газар дээрх хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй, илэрсэн бол зөрчлийг арилгах талаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байх;

4.2.7. Хороонд төвлөрүүлэх зохицуулалтын хөлсийг төлсөн байна.

4.3. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн ХЗХ нь энэ журмын 4.2-т зааснаас гадна 3.4.3.б-т заасан нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан байна.

4.4. Хорооноос салбар байгуулах зөвшөөрөл хүссэн ХЗХ нь энэ журмын 4.2-т зааснаас гадна дараах нэмэлт нөхцөл, шаардлагыг хангана:

4.4.1. Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 2 улирал дараалан хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байх;

4.4.2. салбарын байршлыг сонгохдоо гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан нөхцөлийг хангасан байх;

4.4.3. салбарт ажиллах захирал, нягтлан бодогч нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-т заасан шаардлагыг хангасан байх;

4.4.4. ажлын байр, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн програм хангамж нь тухайн ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл шаардлага хангасан байна.

4.5. Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл хүссэн ХЗХ нь энэ журмын 4.2.1, 4.2.3-т зааснаас гадна нэрийг өөрчлөх нь гишүүдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, төөрөгдүүлэхгүй байх шаардлагыг хангана.

4.6. Өөрчлөн байгуулах зөвшөөрөл хүссэн ХЗХ нь дараах шаардлагыг хангана:

4.6.1. Өөрчлөн байгуулагдсанаар тухайн ХЗХ-ны гишүүдийн эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэхгүй, хохирол учруулахгүй байх;

4.6.2. өөрчлөн байгуулах шийдвэр гарснаас хойш ажлын 14 хоногийн дотор Хороо болон гишүүд, харилцагчдад энэ тухайгаа бичгээр мэдэгдэх;

4.6.3. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 47 дугаар зүйлд заасныг мөрдлөг болгоно.

4.7. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах зөвшөөрөл хүссэн ХЗХ нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

4.7.1. Хорооноос тавьж байгаа зайны болон газар дээрх хяналт, шалгалтаар хангалттай гэсэн үнэлгээ авсан байх;

4.7.2. үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 улирал дараалан ханган ажиллаж, санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг журамд заасан хугацаанд ирүүлсэн байх;

4.7.3. тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 45 хоногийн өмнө Хороонд холбогдох баримт бичгийг бүрдүүлж ирүүлсэн байх;

4.7.4. Хорооны бүртгэлийн ажилтан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 2 сарын өмнө уг ХЗХ-нд Хороонд бүртгүүлсэн цахим хаягаар энэ тухай мэдэгдэл хүргүүлнэ.

ТАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

5.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн ХЗХ нь "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын дагуу өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ01001-ын дагуу гаргаж, 2 дугаар хавсралтын (А)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсаргаж ирүүлнэ.

5.2. ХЗХ нь санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх, салбар байгуулах, оноосон нэр өөрчлөх, өөрчлөн байгуулах, тусгай зөвшөөрөл сунгуулах зөвшөөрөл хүссэн "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын дагуу өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ01002-ын дагуу гаргаж, зөвшөөрлийн төрлөөс хамааруулан 2 дугаар хавсралтын (Б)-(Е)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсаргаж ирүүлнэ.

5.3. ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон ХЗХ-г өөрчлөн байгуулах зөвшөөрөл олгохтой холбогдсон өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хүлээн авч хянаж, Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.4. ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх, салбар байгуулах, эдгээр зөвшөөрлийг хүчингүй болгох болон оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгохтой холбогдсон өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж Хорооны дарга шийдвэрлэнэ.

5.5. Холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасны дагуу ажлын 45 хоногийн дотор, ХЗХ-г өөрчлөн байгуулах зөвшөөрөл олгох эсэх асуудлыг мөн хуулийн 47 дугаар зүйлийн хуулийн 47.4-т заасны 30 хоногийн дотор, бусад зөвшөөрлийг олгох эсэх тухай асуудлыг ажлын 14 хоногийн дотор багтаан шийдвэрлэнэ.

5.6. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэр, улсын тэмдэгтийн хураамж төлсөн нотлох баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

5.7. ХЗХ-г өөрчлөн байгуулах эсхүл оноосон нэр өөрчлөхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэр, холбогдох зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн нотлох баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгоно.

5.8. ХЗХ-ны салбар байгуулахыг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийг үндэслэн салбарын гэрчилгээг олгоно.

5.9. Энэ журмын 5.6, 5.7, 5.8-д зааснаас бусад зөвшөөрөл олгосон шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн нотлох баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээ хийнэ.

5.10. ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, бүртгүүлснээс хойш ажлын 14 хоногийн дотор өөрчлөлт оруулсан улсын бүртгэлийн гэрчилгээ болон улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрэм /өөрчлөлт оруулсан дүрэм/-ийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

ЗУРГАА. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

6.1. ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөлд дурдсан мэдээлэл буруу, дутуу, баримт бичгийг хууль, журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлээгүй, мөн "ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын дагуу ирүүлээгүй, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасныг үндэслэн Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гаргаж, энэ тухай хариуг албан бичгээр өгнө.

6.2. Хорооноос тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд Хороо Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7-д заасныг үндэслэн тухайн ХЗХ-г татан буулгах, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулахаар ХЗХ, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

6.3. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-т заасны дагуу ХЗХ-г өөрчлөн байгуулах зөвшөөрөл өгөхөөс Хороо татгалзаж болно.

6.4. ХЗХ нь тусгай зөвшөөрөл сунгуулах өргөдөл, баримт бичгээ ирүүлээгүй тохиолдолд Хорооны хянан шалгагч тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцуулахаар шийдвэрлүүлнэ.

6.5. Ирүүлсэн баримт бичгийг хууль, журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлээгүй тусгай зөвшөөрөл хүсэгчид анх хүсэлт тавьсан өдрөөс хойш 3 сарын хугацаа өнгөрсөн бол тусгай зөвшөөрөл олгохоос, зөвшөөрөл хүсэгчид анх хүсэлт тавьсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн хугацаа өнгөрсөн бол үндэслэл бүхий хариуг албан бичгээр хүргүүлнэ.

6.6. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 1 жилийн дотор хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

ДОЛОО. ХҮСЭЛТИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

7.1. ХЗХ нь өөрийн оршин байгаа газрын хууль ёсны хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан хугацаанд, сонгуульт гишүүд, гүйцэтгэх алба /гүйцэтгэх захирал, нягтлан/-нд өөрчлөлт орсон бол ажлын 10 хоногийн дотор энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СХ301003-ын дагуу

гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралтын (Ж)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгийн хамт Хороонд цаасаар, эсхүл цахимаар ирүүлж, бүртгүүлнэ.

7.2. Хороо нь ХЗХ-ны хүсэлтийн дагуу бүртгэл хийж, ажлын 5 хоногт багтаан хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

7.3. Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ.

7.4. Хороо нь хүсэлтийг бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзана:

7.4.1. сонгуульт гишүүд болох тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4, 34.11-т заасан, хоршооны гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нь мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасан шаардлагыг хангаагүй.

7.4.2. өөрчлөгдсөн хаяг байршил нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3-т заасан нөхцлийг хангахад гишүүдэд хүндрэл учруулахаар бол.

НАЙМ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

8.1. Хороо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

8.1.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2-т заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;

8.1.2. хууль, журмын хэрэгжилтийг хангуулахаар Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, биелэлтийг хангалтгүй гэж үзсэн;

8.1.3. үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 3 улирал дараалан хангаж ажиллаагүй нь санхүү, төлбөрийн чадварт нь сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа;

8.1.4. зайны хяналтаар эрсдэлийн түвшин өндөртэй болон газар дээрх хяналт, шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

8.1.5. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг 2 улирал дараалан Хороонд ирүүлээгүй;

8.1.6. энэ журмын 4.7.3.-т заасныг биелүүлээгүй.

8.1.7. Холбогдох заавар, журмаар тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш сараар хэтрүүлсэн.

8.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл түдгэлзүүлсэн мэдэгдлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу ажлын 3 хоногт багтаан ХЗХ болон харьяа татварын албанд албан бичгээр мэдэгдэнэ.

8.3. Энэ журмын 8.1-д заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн тохиолдолд ХЗХ нь зөрчил, дутагдлаа арилгаж, хэвийн үйл ажиллагаагаа хангасан гэж үзвэл түдгэлзүүлсэн хугацаанд багтаан сэргээлгэх хүсэлтээ энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн маягт СЗХ01002-ын дагуу гаргасан өргөдлөө үүрэг даалгаврын биелэлт, нотлох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

8.4. ХЗХ-ны хүсэлт, хянан шалгагчийн санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг Хороо шийдвэрлэнэ.

8.5. Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэр гарсан өдрөөс ХЗХ нь дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

8.5.1. шинээр хадгаламж татах, зээл гаргах;

8.5.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан аливаа хадгаламж болон зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах;

8.5.3. Хорооноос авсан зөвшөөрөлтэй санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх.

8.6. Хороо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

8.6.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан үндэслэл;

8.6.2. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9-т заасан нөхцөл байдал үүссэн;

8.6.3. Хорооноос хийсэн зайны болон газар дээрх хяналт, шалгалтаар цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй гэж дүгнэсэн;

8.6.4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан үндэслэл үүссэн;

8.6.5. гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасан шаардлагыг хангаагүй;

8.6.6. түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос түдгэлзүүлэх үндэслэл болсон шалтгааныг арилгуулахаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

8.6.7. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.7. ХЗХ нь Хорооноос тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон өдрөөс эхлэн Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасныг мөрдлөг болгоно.

8.8. Дараах нөхцөл байдал үүссэнийг нотолсон тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

8.8.1. өөрөө хүсэлт гаргасан;

8.8.2. энэ журмын 4.2.3-т заасан нийтлэг нөхцөл, шаардлагаас гадна Даатгалын төлөөлөгчийн ажил, үйлчилгээ эрхлэж буй нь энэ журмын 4.4.1, хоршооны салбар нь энэ журмын 4.4.2, 4.4.4-т заасан нөхцөл шаардлагыг зөрчсөн.

8.9. Хүчингүй болгосон мэдэгдлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу ажлын 3 хоногт багтаан ХЗХ, Улсын бүртгэлийн ерөнхий газар, харьяа татварын албанд албан бичгээр мэдэгдэнэ.

8.10. ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд тусгай зөвшөөрөл, салбарын гэрчилгээг Хороонд ирүүлэх үүрэг хүлээнэ.

8.11. Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, салбарын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Хороо энэ тухай олон

нийтэд мэдээлэн, гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн ХЗХ-ны хувийн хэрэгт хийж, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

8.12. Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гарсан үеэс хадгаламж, зээлийн үйл ажиллагаа нь дуусгавар болно.

8.13. Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гарсан өдрөөс тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг үргэлжлүүлбэл холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

ЕС. ТАТАН БУУЛГАХ


9.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд ХЗХ-г татан буулгах ажиллагааг холбогдох хуулийн дагуу явуулна.

АРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

10.1. ХЗХ-ны үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрт нийцэж байгаа эсэхэд Хороо хяналт тавьж зөрчсөн этгээдэд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 10 дугаар бүлэг заасан болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, СОНГУУЛЬТ
БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА СОЛИГДОХ, ХАЯГ, БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Д/д	Маягтын код	Өргөдлийн маягтын зориулалт
1	СЗХ01001	ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягт
2	СЗХ01002	ХЗХ-ны санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх, салбар байгуулах, оноосон нэр өөрчлөх, өөрчлөн байгуулах, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээлгэхийг хүссэн өргөдлийн маягт
3	СЗХ01003	ХЗХ-ны сонгуульт болон гүйцэтгэх удирдлага солигдох, хаяг, байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийн маягт

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он	Сар	Өдөр
Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан эсэх			Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол хаана, ямар үйл ажиллагааг, хэдий хугацаагаар эрхэлсэн талаар бичих			
Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан эсэх			Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол хэдийд ирүүлсэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар бичих			
I. ХЗХ-ны ерөнхий мэдээлэл			
Өргөдөл гаргасан ХЗХ-ны нэр:	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)		
Оноосон нэрэнд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/	Нэр _____ Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тэр нэр ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)		
Үүсгэн байгуулагдсан огноо	____ /он/ ____ /сар/ ____ /өдөр/ (Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан хурлын огноог бичих)		
Улсын бүртгэлийн дугаар			
Регистрийн дугаар			
ХЗХ-ны гишүүдийн тоо			
Гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө /₮/			
Харилцах <input type="checkbox"/>	Банкны нэр		
	Дансны дугаар		
	Үлдэгдэл /₮/		
Хадгаламж <input type="checkbox"/>	Банкны нэр		
	Дансны дугаар		
	Үлдэгдэл /₮/		
Хаяг байршил:	Аймаг/ хот		
	Сум/дүүрэг		
	Баг/хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
Холбоо барих утас:	Суурин	Гар утас	Факс
Цахим хуудас:			

Цахим хаяг:							
ХЗХ-ны гишүүнчлэлийн хамрах хүрээ (Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан дараах нөхцөлүүдээс тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих)							
Нэг байгууллагад ажилладаг							
<input type="checkbox"/> Үйл ажиллагааны чиглэл адил нийгэмлэг, холбоонд гишүүнчлэлтэй <input type="checkbox"/> Нэг сум/ хорооны харьяалалтай <input type="checkbox"/> Нэг дүүрэгт харьяалалтай <input type="checkbox"/> Нэг хот/ аймгийн харьяалалтай							
II. Үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл (Овог, нэрийг бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн дүнг бичих)							
№	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Хувь нийлүүлсэн хөрөнгө /₮/			
<i>Тэмдэглэл: Үүсгэн байгуулагч, гишүүн бүрийг жагсаан бичих.</i>							
III. Сонгуульт болон гүйцэтгэх удирдлагын мэдээлэл							
а/ Тэргүүлэгчдийн зөвлөлийн бүрэлдэхүүн							
№	Овог, нэр	Дарга / гишүүн	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	мэргэжил		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил
<i>Тэмдэглэл: Зөвлөлийн гишүүн бүрийг бичих.</i>							
б/ Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн							
№	Овог, нэр	Дарга / гишүүн	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	Эзэмшсэн мэргэжил		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил
<i>Тэмдэглэл: Зөвлөлийн гишүүн бүрийг бичих.</i>							
в/ Зээлийн хорооны бүрэлдэхүүн							
№	Овог, нэр	Дарга / гишүүн	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	Эзэмшсэн мэргэжил		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил
<i>Тэмдэглэл: Хорооны гишүүн бүрийг бичих.</i>							
г/ Гүйцэтгэх албаны бүрэлдэхүүн							
№	Албан тушаал	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Эзэмшсэн мэргэжил		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил

Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг бичих.

IV. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл

Худалдаж авсан
 Түрээсэлсэн
 Бусад / тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих./

Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байх.

V. Ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

Тэмдэглэл: Техник, тоног төхөөрөмж бүрээр бичих.

VI. Ашиглах програм хангамжийн мэдээлэл

	Програм хангамжийн нэр төрөл	Зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

Тэмдэглэл: Програм хангамж бүрээр бичих.

VII. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт (оссон дүнгээр)

Үзүүлэлтүүд	___ он	___ он	___ он
Эрхлэх үйл ажиллагааны чиглэл			
Нийт хөрөнгө			
Өөрийн хөрөнгө			
Хувь нийлүүлсэн хөрөнгө			
Бусдаас татсан эх үүсвэр			
Нийт орлого			
Нийт зарлага			
Өөрийн хөрөнгийн өгөөж			
Активын өгөөж			

Тэмдэглэл: Бизнес төлөвлөгөөтэй уялдуулан тодорхойлох.

Өргөдөл гаргасан:

Үүсгэн байгуулагч гишүүд

_____ /Овог, нэр /	_____ гарын үсэг	_____ огноо
_____ /Овог, нэр /	_____ гарын үсэг	_____ огноо
_____ /Овог, нэр /	_____ гарын үсэг	_____ огноо
_____ /Овог, нэр /	_____ гарын үсэг	_____ огноо
_____ /Овог, нэр /	_____ гарын үсэг	_____ огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт

Маягт СЗХ01002
(ХЗХ)

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он	Сар	Өдөр				
Өргөдөл гаргагч ХЗХ-ны нэр							
Регистрийн дугаар							
Зөвшөөрлийн төрлийг сонгож тохирох нүдэнд "✓" тэмдгийг тавих							
Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх:		<input type="checkbox"/> Салбар байгуулах <input type="checkbox"/> Оноосон нэр өөрчлөх <input type="checkbox"/> Өөрчлөн байгуулах <input type="checkbox"/> Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах <input type="checkbox"/> Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээлгэх					
<input type="checkbox"/> Санхүүгийн түрээсийн үйлчилгээ <input type="checkbox"/> Төслийн санхүүжилт <input type="checkbox"/> Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах <input type="checkbox"/> Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа <input type="checkbox"/> Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ <input type="checkbox"/> Хуримтлалын сан үүсгэх, удирдах							
I. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх							
Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар		_____/он/ ____/сар/ ____/өдөр/ ____/дугаар/					
Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх зайлшгүй шаардлага							
Тэмдэглэл: Хуримтлалын сан үүсгэх, удирдах зөвшөөрөл хүсэх тохиолдолд							
Хуримтлагдсан хөрөнгийг өсгөж, үр ашигтай удирдах хөрөнгө оруулалтын мэргэжилтний мэдээлэл							
№	Овог, нэр	Албан тушаал	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	мэргэжил		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил
II. Салбар байгуулах							
Салбар байгуулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар				_____/он/ ____/сар/ ____/өдөр/ ____/дугаар/			
Салбарын оноосон нэр (Хуулийн этгээдийн оноосон нэртэй ижил байх)							
Салбарын хаяг байршил (ХЗХ-ны шинэчлэн баталсан дүрэмд тусгагдсан хаяг байршилын мэдээлэлтэй ижил байх)		Аймаг/ хот					
		Сум/дүүрэг					
		Баг/хороо					
		Гудамж, байр					
		Тоот					
Холбоо барих утас		Суурин		Гар утас		Факс	
Цахим хаяг:							
Салбарын боловсон хүчний мэдээлэл							
№	Албан тушаал	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Эзэмшсэн мэргэжил		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил

Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг бичих.						
Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл						
<input type="checkbox"/> Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээслэсэн <input type="checkbox"/> Бусад /тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих./						
Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байх.						
Салбарт ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл						
№	Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Тэмдэглэл: Техник, тоног төхөөрөмж бүрээр бичих.						
Ашиглах програм хангамжийн мэдээлэл						
№	Програм хангамжийн нэр, төрөл	Зориулалт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Тэмдэглэл: Програм хангамж бүрээр бичих.						
III. Оноосон нэр өөрчлөх						
Оноосон нэр өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар				_____/он/ ____/сар/ ____/өдөр/ /дугаар/		
ХЗХ-ны шинэ нэр (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичих)						
ХЗХ-ны оноосон нэр өөрчлөх шаардлага						
IV. Өөрчлөн байгуулах						
Өөрчлөн байгуулагдах хэлбэр (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавих)				<input type="checkbox"/> Нэгтгэх <input type="checkbox"/> Нийлүүлэх		
№	Өөрчлөн байгуулагдаж байгаа ХЗХ-ны нэр	Регистрийн дугаар	Хорооноос анх тусгай зөвшөөрөл авсан шийдвэрийн огноо, дугаар	Өөрчлөн байгуулагдах шийдвэр гаргасан бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар	Хоршоо тус бүрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	
Өөрчлөн байгуулагдсаны дараа шинээр үүсэх ХЗХ-ны оноосон нэр						
Өөрчлөн байгуулагдах болсон үндэслэл, шалтгаан						
Тэмдэглэл: Өөрчлөн байгуулагдах ХЗХ тус бүрийг бичих. Өргөдөл гаргасан хэсэгт өөрчлөн байгуулагдаж буй ХЗХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга тус бүр гарын үсэг зурж, дамга дарах.						
V. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах						
Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын шийдвэрийн огноо, дугаар				_____/он/ ____/сар/ ____/өдөр/ /дугаар/		
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа						
VI. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээлгэх						
Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл түдгэлзүүлсэн Хорооны шийдвэрийн огноо, дугаар				_____/он/ ____/сар/ ____/өдөр/ /дугаар/		


Өргөдөл гаргасан : _____

Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт



**Маягт СЗХ01003
(ХЗХ)**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛЬТ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ
УДИРДЛАГА СОЛИГДОХ, ХАЯГ, БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр			
Өргөдөл гаргагч ХЗХ-ны нэр								
Регистрийн дугаар								
Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгох (тохирох нүдэнд "✓" тэмдгийг тавих)								
<input type="checkbox"/> Сонгуульт болон гүйцэтгэх удирдлага солигдох <input type="checkbox"/> Хаяг, байршлын өөрчлөлт								
I. Шинэ сонгуульт болон гүйцэтгэх удирдлагын мэдээлэл								
№	Сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал	Сонгосон/ томилсон шийдвэрийн огноо, дугаар	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Эзэмшсэн мэргэжил		
						Төгссөн сургууль	Дипломын дугаар	мэргэжил
Тэмдэглэл: Хүн тус бүрийг бичих								
II. ХЗХ-ны шинэ хаяг, байршлийн талаарх мэдээлэл								
ХЗХ-ны дүрэмд шинэ хаяг байршлийг тусгах асуудал хэлэлцсэн бүх гишүүдийн хурлын огноо, шийдвэрийн дугаар					_____ он _____ сар _____ өдөр Дугаар _____			
Хаяг байршил	Аймаг/ хот							
	Сум/дүүрэг							
	Баг/хороо							
	Гудамж, байр							
	Тоот							
Холбоо барих утас								
Тэмдэглэл: ХЗХ-ны шинэ хаяг, байршил нь тухайн хоршооны дүрэмд тусгагдсан байх.								

Өргөдөл гаргасан:

_____ Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

_____ гарын үсэг

_____ огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 дугаар хавсралт

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
ЗӨВШӨӨРӨЛ, СОНГУУЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Хавсралтын төрөл	Жагсаалтын зориулалт
1	2 (А) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01001) хавсаргах баримт бичгийн жагсаалт
2	2 (Б) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01002) хавсаргах баримт бичгийн жагсаалт
3	2 (В) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны салбар байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01002) хавсаргах баримт бичгийн жагсаалт
4	2 (Г) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01002) хавсаргах баримт бичгийн жагсаалт
5	2 (Д) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны өөрчлөн байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01002) хавсаргах баримт бичгийн жагсаалт
6	2 (Е) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрөл сунгуулахыг хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01002) хавсаргах баримт бичгийн жагсаалт
7	2 (Ё) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээлгэхийг хүссэн өргөдөлд (Маягт СЗХ01002) хавсаргах баримт бичгийн жагсаалт
8	2 (Ж) дугаар хавсралт	Хадгаламж, зээлийн хоршооны сонгуульт болон гүйцэтгэх удирдлагыг бүртгүүлэх өргөдөлд (Маягт СЗХ01003) хавсаргах баримт бичгийн жагсаалт

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (А) дугаар хавсралт

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮССЭН ӨРГӨДӨЛД (Маягт СЗХ01001) ХАВСАРГАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ


№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	ХЗХ-ны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/	
2	ХЗХ-г үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл, шийдвэр	
3	ХЗХ-ны үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээ /Үүсгэн байгуулагчдын гарын үсгээр баталгаажсан/	
4	ХЗХ-ны дүрэм	
5	Бүх гишүүдийн хурлаар баталсан тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны ажиллах журам, баталсан шийдвэр	
6	Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталсан хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журам, баталсан шийдвэр	
7	Гишүүдийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг банкин дахь тухайн ХЗХ-ны дансанд байршуулсныг нотлох дансны хуулга	
8	Эрсдэлээс хамгаалах арга хэмжээ, санхүүгийн үр дүнг тооцсон бизнес төлөвлөгөө /бүх гишүүдийн хурлаар баталсан, 3 жилээс доошгүй хугацааг хамарсан/	
9	Үүсгэн байгуулагч гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана /нотариатаар гэрчлүүлсэн/.	
10	Санхүүгийн эхлэлтийн тайлан тэнцэл	
11	Гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн мэргэжил, мэргэшил, ур чадварыг тодорхойлох мэдээлэл /мэргэжлийн диплом, үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох зохих байгууллагын тодорхойлолт /	
12	Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны дарга, гишүүд болон гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар нь сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй тухай тухайн этгээдээс гаргасан тодорхойлолт	
13.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу хяналт тавих ажилтныг томилсон шийдвэр	

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (Б) дугаар хавсралт

**ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САНХҮҮГИЙН БУСАД
АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН
ӨРГӨДӨЛД (Маягт СЗХ01002) ХАВСАРГАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх болон дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр	
2	Эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний төрлийг тусгасан дүрмийн өөрчлөлт	
3	Тухайн ажил үйлчилгээнд мөрдөх журам, түүнийг баталсан тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр	
4	Нэмэлт өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө, тухайн ажил үйлчилгээний санхүүгийн үр ашгийн тооцоо	
5	Хуримтлалын сан үүсгэх, удирдах зөвшөөрөл хүссэх тохиолдолд хөрөнгө оруулалтын мэргэжилтний иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/	


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (В) дугаар хавсралт



ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР БАЙГУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (Маягт СЗХ01002)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Салбар байгуулах болон дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр	
2	Өөрчлөлт орсон дүрэм	
3	Салбарын үйл ажиллагаанд мөрдөх журам	
4	Нэмэлт өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоо	
5	Салбарын захирал, нягтлан бодогч нарыг томилсон шийдвэр, тэдгээрийн иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/, эсхүл тухайн орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох зохих байгууллагын тодорхойлолт	
6	Салбарын захирал, нягтлан бодогч нар нь сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй тухай тухайн этгээдээс гаргасан тодорхойлолт	


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (Г) дугаар хавсралт



**ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ОНООСОН НЭР ӨӨРЧЛӨХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (Маягт СЗХ01002)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Оноосон нэрийг өөрчлөх болон дүрэмд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр	
2	Өөрчлөлт орсон дүрэм	
3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас	
4	Оноосон нэрийг өөрчлөх хүсэлт гаргах үеийн санхүүгийн тайлан, гишүүдийн хадгаламж, зээл, хувь хөрөнгө болон өр төлбөр, авлагын дэлгэрэнгүй бүртгэл	
5	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь	


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (Д) дугаар хавсралт



ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (Маягт СЗХ01002)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	ХЗХ-г өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр	
2	Гишүүд, тэдгээрийн хадгаламж, зээл болон хувь нийлүүлсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл;	
3	Өөрчлөн байгуулах үеийн санхүүгийн тайлан	
4	Өр төлбөр ба авлагын дэлгэрэнгүй бүртгэл, өөрчлөн байгуулахад эдгээрийг хэрхэн шийдвэрлэх тухай ХЗХ-ны шийдвэр, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн акт, байгуулсан гэрээ	
5	Өөрчлөн байгуулах үйл ажиллагаатай холбоотой удирдлага зохион байгуулалт, гарах зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай шийдвэр	
А. Нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд:		
6	Нийлж байгаа ХЗХ тус бүрийн тэргүүлэгчдийн зөвлөлийн өөрчлөн байгуулах шийдвэр болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ	
7	Шинээр байгуулагдах ХЗХ-ны дүрмийн төслийг ХЗХ тус бүрийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, шийдвэр	
8	Өөрчлөн байгуулагдсанаас үүсэх санхүүгийн үр дүнгийн тооцоо	
9	Шинээр байгуулагдах ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт	
Б. Нэгдэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд:		
10	Нэгтгэж байгаа ХЗХ-ны дүрэм	
11	Нэгдэж байгаа ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	
12	Өөрчлөн байгуулагдсанаас үүсэх санхүүгийн үр дүнгийн тооцоо	
13	Өөрчлөн байгуулагдсаны дараах хуулийн этгээдийн эхлэлтийн тайлан тэнцэл	


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (Е) дугаар хавсралт



**ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
СУНГУУЛАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (Маягт СЗХ01002)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах асуудал хэлэлцсэн тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь	
2	Хүсэлт гаргах үеийн санхүүгийн тайлан, мэдээ	
3	Хадгаламж, зээл, хувь хөрөнгө, гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл	
4	Бизнес төлөвлөгөө	


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (Е) дугаар хавсралт



ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ
СЭРГЭЭЛГЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (Маягт **СЗХ01002**)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Зөрчил дутагдлыг арилгаж, өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон түүнийг нотлох баримт бичгийн хуулбар	


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 2 (Ж) дугаар хавсралт



**ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛЬТ
БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ БҮРТГҮҮЛЭХ
ӨРГӨДӨЛ (Маягт СЗХ01003)**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Сонгуульт гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг өөрчилсөн шийдвэр	
2	Шинээр сонгуульт гишүүнээр сонгогдсон эсхүл гүйцэтгэх удирдлагаар томилогдсон этгээд нь сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй тухай тухайн этгээдээс гаргасан тодорхойлолт	
3	Шинээр томилогдсон гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн мэргэжил, мэргэшил, ур чадварыг тодорхойлох мэдээлэл /мэргэжлийн диплом, үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох зохих байгууллагын тодорхойлолт/	
4	Шинээр томилогдсон гүйцэтгэх удирдлагын анкет /"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт нөхөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан/	

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 3 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны _____ оны _____ сарын _____ өдрийн _____ дугаар _____ тогтоолоор

-д

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

Энэ гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй.



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

_____ ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Хадгаламж, зээлийн хоршоонд зориулсан тэмдэглэлүүд

Энэ хавсралт нь тусгай
зөвшөөрлийн гэрчилгээний
хамт хүчинтэй

НЭГ. Хадгаламж, зээлийн хоршооны оноосон нэр: _____

ХОЁР. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас, факс, и-мэйл хаяг	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ГУРАВ. Тусгай зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар
Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх			

ДӨРӨВ. Тусгай зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тэмдэглэл	Тогтоолын огноо	Тогтоолын дугаар	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ТАВ. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн тэмдэглэл:

ТАВ. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Зөвшөөрлийн нэр	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ЗУРГАА. Хадгаламж, зээлийн хоршооны салбарын тэмдэглэл:

Д/д	Салбарын нэр, дугаар	Салбарын хаяг, хаягийн өөрчлөлт	Салбарт зөвшөөрөл олгосон огноо	Салбарт зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Салбарын зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ДОЛОО. Тусгай зөвшөөрлийн сунгалтын тэмдэглэл:

Д/д	Сунгалтын тэмдэглэл	Сунгах зөвшөөрөл олгосон огноо	Сунгах зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны
зохицуулалтын журам"-ын 4 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
САЛБАРЫН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын _____ оны _____ сарын _____ өдрийн _____ дугаар тушаалаар _____ хот/аймаг/ дахь _____ регистрийн дугаар бүхий _____ тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй

_____ ХЗХ-нд
_____ хот/аймаг/ _____ дүүрэг /сум/

(салбарын нэр, дугаар)

байгуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН МАЯГТ
БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү зааврыг хадгаламж, зээлийн хоршоо /цаашид "ХЗХ" гэх/-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичгийг бүрдүүлэхэд ХЗХ, тэдгээрийн үүсгэн байгуулагч, удирдлагууд мөрдлөг болгоно.

**ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ,
БАРИМТ БИЧИГ БҮРДҮҮЛЭХ**

А.Тусгай зөвшөөрлийн СЗХ01001 маягтыг бөглөх заавар

ХЗХ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсний дараа Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Хороонд хандана.

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны <http://frc.gov.mn/> цахим хуудас дахь "цахим" өргөдлийн маягт цонхонд хандаж цахимаар бөглөнө. Өргөдлийн маягтыг цаасаар бөглөх тохиолдолд тус цахим хуудаснаас татаж авна.

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, хуулийн этгээдийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд "√" тэмдгийг тавина.

Хэсэг 1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

1.1. Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирил үсгээр, бүтэн бичнэ.

Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.

ХЗХ-ны оноосон нэр нь улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн хуулийн этгээдийн нэр байна.

1.2. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.

1.3. Улсын бүртгэлийн болон регистрийн дугаарыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичсэний дагуу нөхнө.

1.4. Гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь улсын бүртгэлийн гэрчилгээ болон эхлэлтийн тайланд тусгагдсан дүнтэй ижил байна.

1.5. Дансны төрлийг сонгож, банкны нэр, дансны дугаарыг бичиж, холбогдох дансны үлдэгдлийг төгрөгөөр илэрхийлнэ.

1.6. Хаяг байршил хэсэгт хуулийн этгээдийн одоо байгаа, эсхүл гэрээ байгуулсан байрны хаягийг, хүснэгт дэх асуулгын дагуу дэлгэрэнгүй бичих бөгөөд хаяг байршлыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлсэн байна.

1.7. Цахим хаяг, цахим хуудас нүдэнд хуулийн этгээдийн албан ёсны цахим хаяг, хуудсыг бичнэ.

1.8. ХЗХ-ны гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан дараах нөхцөлийн алинд хамаарахыг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Хэсэг 2. Гишүүдийн мэдээлэл

2.1. Үүсгэн байгуулагч гишүүдийн овог, нэрийг бүтэн бичиж, мэдээллийг хүснэгтийн дагуу оруулахдаа овог, нэр, регистрийн дугаар, оршин суух хаяг, утасны дугаар болон хуулийн этгээдэд оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бичнэ.

Хэсэг 3. Сонгуульт ажилтнууд болон боловсон хүчний мэдээлэл

3.1. Сонгуульт ажилтнуудын овог нэр, сонгогдсон албан тушаал, регистрийн дугаар, ажлын хаяг, эзэмшсэн мэргэжил зэргийг тодорхой бичнэ.

3.2. ХЗХ-ны ажилтнуудын албан тушаал, овог нэр, регистрийн дугаар, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, эзэмшсэн мэргэжил зэргийг тодорхой бичнэ.

3.3. ХЗХ-ны сонгуульт болон гүйцэтгэх ажилтнууд энэхүү зааврын хавсралт 1-ийн дагуу анкет бөглөж, сүүлийн 1 жилд авахуулсан 3*4 хэмжээтэй цээж зургийг наана. Хэрэв цахимаар бөглөж байгаа тохиолдолд цээж зургийг байршуулна.

Хэсэг 4. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл

4.1. Ажлын байр хэсэгт тухайн ажлын байрыг худалдаж авсан, түрээсэлсэн аль нь болохыг бичих бөгөөд энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байна.

Хэсэг 5. Ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл

5.1. Үйл ажиллагаанд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бөглөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан, түрээсэлсэн аль нь болохыг тодорхой бичнэ.

Хэсэг 6. Ашиглах програм хангамжийн мэдээлэл

6.1. Програм хангамжийн зориулалт багананд тухайн програмын талаар холбогдох мэдээллийг мэдээллийг бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэлийн програм.

Хэсэг 7. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төсөөлөл

7.1. Эрхлэх үйл ажиллагааны чиглэл, элсэх гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгө, бусдаас татах эх үүсвэр, орлого, зарлага, хүлээгдэж буй үр ашгаа 3 жилээр тооцоолж, өссөн дүнгээр нь гаргана. Бизнес төлөвлөгөөг дараах зөвлөмжийн дагуу боловсруулна.

Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь ХЗХ-ны хэтийн зорилго, зорилтыг тодорхойлж, хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх албан тушаалтнуудын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын

үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаатайгаар төлөвлөн боловсруулсан бодлогын баримт бичиг, жил жилийн хүрэх үр дүнг тоон үзүүлэлтээр илэрхийлсэн, тооцоолсон судалгааг хэлнэ.

2. ХЗХ-ны бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах асуудлыг хамруулсан байна:

- 2.1. ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, хэтийн төлөв байдал;
- 2.2. гишүүнчлэлийн хүрээ;
- 2.3. хүний нөөцийн төсөөлөл;
- 2.4. үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ, танилцуулга;
- 2.5. ХЗХ-ны тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого, зарлагын 3 жилийн төсөөлөл;
- 2.6. Актив, пассивын бүтэц, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, орлого, зарлагын болон үр ашгийн төлөвлөлт, төсөөлөл;
- 2.7. Үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ;

3. Бизнес төлөвлөгөөг ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

3.1. Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- ХЗХ-ны нэр, хаяг;
- Бизнес төлөвлөгөөний нэр;
- Боловсруулсан огноо;
- Баталсан шийдвэрийн огноо, дугаар;
- Боловсруулсан хүний нэр, хаяг;
- Боловсруулсан хүний тэмдэглэл;
- ХЗХ-ны удирдлагын нэр, хаяг.

3.2. Гүйцэтгэлийн хураангуй

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг ХЗХ-ны үйл ажиллагааны зорилго, зорилт, хэтийн төлөв, төлөвлөгөө, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдэд тулгуурлаж бичсэн байна.

3.3. Бизнесийн танилцуулга:

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес төлөвлөгөөний зорилго;
- Бизнесийг хөгжүүлэх тухай;
- Явуулах бүтээгдэхүүн үйлчилгээний судалгаа;
- Зах зээлийн нөхцөл төлөв байдалд хийсэн дүгнэлт;

3.4. Менежментийн төлөвлөгөө

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт ХЗХ-ны удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээний судалгааг оруулна.

Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт тэргүүлэгчид нь Хоршооны хууль, удирдлагаар мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямар болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан, болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан зэргийг харуулах хэрэгтэй. Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл болон гүйцэтгэх албан тушаалтнууд (гүйцэтгэх захирал г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн сонгуульт албан тушаалтнуудын эрх үүрэг, хариуцлагыг тогтоож, хэн нь хэндээ захирагдах, хэн эцсийн шийдвэр гаргахыг зааж, байгууллагын дүрэмээр баталгаажуулж, төлөвлөгөөнд хавсаргана..

Зохион байгуулалтын бүтэц: тэргүүлэгчид нь ХЗХ-ны удирдлага зохион байгуулалтыг шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай байхаар бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажиллагсдын ажлын үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэ зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож, орон тоо, цалин, урамшууллыг тооцон бизнес төлөвлөгөөндөө тусгана.

Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний тоо, түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөх болно.

Нийт ажиллагсад болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо, түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалин, урамшууллын хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

/Сургалтад зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашиг зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой./

3.5. Санхүүгийн төлөвлөгөө

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно:

- Нийт орлогын тооцоо;
- Үйл ажиллагааны урсгал зардлын тооцоо;
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо;
- Мөнгөн урсгалын тооцоо гэх мэт.

3.6. Эрсдэлийн шинжилгээ

Эрсдэлийн төрлүүд: ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэхэд үндсэн 5 төрлийн эрсдэлийг тооцоолно. Үүнд:

- Санхүүгийн болон хадгаламж, зээл;
- Хууль, эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт;
- Хүний хүчин зүйлс, засаглал, удирдлага;
- Техник, тоног төхөөрөмж, бүртгэлийн програм;
- Давагдашгүй хүчин зүйл байгалийн гамшиг.

3.7. Эрсдэлийг багасгах боломжууд

Эдгээр дурдсан эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснийг бичих нь зүйтэй. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

4. Санхүүгийн шинжилгээ: Сангийн сайдын 2013 оны 277 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал"-ын дагуу санхүүгийн шинжилгээг хийнэ.

№	Санхүүгийн шинжилгээний төрөл	Тайлбар
1.	Хөрөнгийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ	Санхүүгийн байдлын өөрчлөлтийг харуулна.
2.	Төлбөрийн чадварын шинжилгээ	Өр төлбөрөө барагдуулах хугацаа, боломжийг харуулна.
3.	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	Хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдуулан оршин тогтнох чадварыг харуулна.
4.	Эргэцийн шинжилгээ	Эргэлтийн хөрөнгийн нэг хэлбэрээс нөгөөд шилжих хөдөлгөөнийг илэрхийлэх бөгөөд үр ашиг нэмэгдэх боломжийг харуулна.
5.	Бүтээмжийн шинжилгээ	Хөдөлмөрийн бүтээмжийг харуулна.
6.	Үндсэн хөрөнгийн шинжилгээ	Үндсэн хөрөнгийн ашиглалтын байдлыг харуулна.
7.	Орлого үр дүнгийн шинжилгээ	Орлогын хичнээн хувь нь юунд хэрхэн зарцуулагдсаныг харуулна.
8.	Ашигт ажиллагааны шинжилгээ	Хөрөнгийн нэгж тутмаас олсон ашгийн хэмжээг илэрхийлнэ.

Мөн үйл ажиллагаа эрхлэхэд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрээ нэмэгдүүлэх нөөц, боломж, зах зээлийн хүртээмжтэй байдал, ашигт ажиллагаа зэргийг харгалзан үзэж, үр дүнгээ тодорхойлохыг зөвлөж байна.

Б. Баримт бичиг бүрдүүлэх

Тусгай зөвшөөрлийн СЗХ01001 маягтаар гаргасан өргөдөлд, "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 2 дугаар хавсралт (А)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан байна. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу үүсгэн байгуулах хуралд бүх гишүүд оролцсон байх ба гаргасан тогтоолд хурлын дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажсан байна. Мөн хуулийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл нь хурал удирдсан дарга, нарийн бичгийн дарга болон хуралд оролцсон бусад үүсгэн байгуулагчдын гарын үсгээр баталгаажуулсан байна;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу үүсгэн байгуулагчдын эрх, үүрэг, хариуцлага, оруулах хувь хөрөнгийн хэмжээ,

тэдгээрийг захиран зарцуулах асуудлыг тусгасан гэрээ байгуулж, үүсгэн байгуулагчид гарын үсэг зуруулсан байна;

- ХЗХ-ны дүрэм нь түүний үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг бөгөөд түүнийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу боловсруулж, бүх гишүүдийн хурлаар батлуулсан байна;
- Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны ажиллах журмыг бүх гишүүдийн хурлаар батлуулсан байна;

Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны ажиллах журам болон зээл, хадгаламжийн болон бусад үйл ажиллагааны журмыг боловсруулахдаа АХБ-ны төслийн хүрээнд Хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос бэлтгэн гаргасан ХЗХ-дын үйл ажиллагаанд мөрдөх бодлого, журмын үлгэрчилсэн гарын авлагад байгаа загварын дагуу боловсруулж болно;

- Мөрдөж ажиллах зээл, хадгаламжийн болон бусад үйл ажиллагааны журмыг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар батлуулсан байна;
- ХЗХ-ны гишүүдийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг банкинд байршуулсныг нотлох дансны гүйлгээний хуулгыг банкны ажилтнаар баталгаажуулсан байна;
- ХЗХ-ны бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилийн хугацаатай боловсруулж, бүх гишүүдийн хурлаар батлуулсан байна;
- Гишүүдийн хувь оролцоог мөнгөн дүнгээр илэрхийлж, гишүүн тус бүрийн нэр дээр бүртгэсэн байна;
- Эхлэлтийн тайлан тэнцлийг энэ зааврын 2 дугаар хавсралтын дагуу гаргана;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11 дэх хэсэгт заасны дагуу тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн нь банк, санхүү, хуулийн мэргэжилтэйг нотлох дипломын хуулбар, эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох тодорхойлолт байвал зохино. Мөн МХЗХҮХ-ноос зохион байгуулсан сургалтанд хамрагдсан байна;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу хяналт тавих /бусад ажил үүрэгтэй хавсран гүйцэтгэж болно/ ажилтныг гүйцэтгэх захирлын тушаалаар томилох бөгөөд шийдвэрээ ирүүлнэ.

ГУРАВ. ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

А. Зөвшөөрөл хүссэн өргөдлийн СЗХ01002 маягтыг бөглөх

Өргөдөл гаргагчийн нэр нүдэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ.

Нэмэлт зөвшөөрлийн төрлийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина. Сонгосон төрлөөс хамаарч санхүүгийн бусад ажил үйлчилгээ нэмж эрхлэх бол 1 дүгээр хэсгийг, салбар байгуулах бол 2 дугаар хэсгийг, оноосон нэр өөрчлөх бол 3 дугаар хэсгийг гэх мэтээр өргөдлийн тохирох хэсгийг нөхнө.

Хэсэг 1. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ нэмж эрхлэх

1.1. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ, төслийн санхүүжилт, цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа, мөнгөн гуйвуулгын

үйлчилгээ, хуримтлалын сан үүсгэж, удирдах зөвшөөрөл хүсч буй ХЗХ нь үйлчилгээнийхээ төрлийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

1.2. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ нэмж эрхлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дугаар, огноог бичнэ. Шийдвэр нь ХЗХ-ны дүрэмд тусгагдсан байна.

1.3. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ нэмж эрхлэх хэрэгцээ, шаардлагаа бизнес төлөвлөгөөтэй уялдуулан товч тодорхойлж бичнэ.

1.4. Хуримтлалын сан үүсгэн, удирдах зөвшөөрөл хүсэх тохиолдолд хуримтлагдсан хөрөнгийг өсгөж, үр ашигтай удирдах хөрөнгө оруулалтын мэргэжилтний мэдээлэл овог нэр, сонгогдсон албан тушаал, регистрийн дугаар, эзэмшсэн мэргэжил зэргийг хүснэгтэд тодорхой бичнэ.

Хэсэг 2. Салбар байгуулах

2.1. Салбар байгуулах зөвшөөрөл хүссэн бол салбар байгуулах асуудлыг шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар, салбарын нэр, хаяг байршлыг тодорхой бичнэ.

2.2. Салбарын ажилтнуудын албан тушаал, овог нэр, иргэний регистрийн дугаар, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, эзэмшсэн мэргэжил зэргийг тодорхой бичнэ.

2.3. Салбарын үйл ажиллагаа явуулах ажлын байр, үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээллийг нөхөхдөө СЗХ01001 маягтыг бөглөх зааврын 4 дэх хэсэгт заасан зөвлөмжийн үзнэ үү.

Хэсэг 3. Оноосон нэр өөрчлөх

3.1. Оноосон нэр өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын огноо, шийдвэрийн дугаарыг бичнэ.

3.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичнэ.

3.3. Оноосон нэр өөрчлөх зайлшгүй шаардлага болон гишүүдийн эрх ашигт нийцсэн, тэднийг төөрөгдүүлэхгүй талаар товч бичнэ.

Хэсэг 4. Өөрчлөн байгуулах

4.1. Өөрчлөн байгуулагдах хэлбэрийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

4.2. Өөрчлөн байгуулагдах ХЗХ-ын оноосон нэр, регистрийн дугаар, анх тусгай зөвшөөрөл авсан шийдвэрийн огноо, дугаар, өөрчлөн байгуулагдах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар, ХЗХ тус бүрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үнэн зөв бичнэ.

4.3. Өөрчлөн байгуулагдсаны дараа шинээр үүсэх ХЗХ-ны оноосон нэрийг бичнэ. Шинээр оноосон нэр сонгож байгаа тохиолдолд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичнэ.

4.4. Өөрчлөн байгуулагдах болсон шаардлага, үндэслэлийг товч бичнэ.

Хэсэг 5. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах

5.1. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах асуудлыг хэлэлцсэн тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн огноо, дугаарыг бичнэ.

5.2. Тусгай зөвшөөрлийн эхэлсэн ба дуусах хугацааг бичнэ.

Хэсэг 6. Тусгай зөвшөөрөл сэргээлгэх

6.1. Зөрчил дутагдлыг арилгаж, өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон түүнийг нотлох баримт бичгийн хуулбар ирүүлнэ.

Б. Баримт бичгийг бүрдүүлэх

Зөвшөөрлийн СЗХ01002 маягтаар гаргасан өргөдөлд, зөвшөөрлийн төрлөөс хамааруулан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 2 дугаар хавсралт (Б)-(Ё)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

1. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ нэмж эрхлэх

- Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл нэмж авах талаар бүх гишүүдийн хурлаар хуралдаж дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна;
- Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх нэмж эрхлэх талаар холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулж, бүх гишүүдийн хурлаас баталсан байна;
- нэмж эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний журмыг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталж шийдвэр гаргасан байна;
- Тухайн ажил үйлчилгээний тооцооллыг хийж бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

2. Салбар байгуулах

- Салбар байгуулах зөвшөөрөл авах талаар бүх гишүүдийн хурлаар хуралдаж дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна;
- Салбар байгуулахтай холбоотойгоор дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулж, бүх гишүүдийн хурлаас баталсан байна;
- Салбарын үйл ажиллагаанд мөрдөх журмыг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталж шийдвэр гаргасан байна;
- Салбар байгуулахтай холбоотой өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоо;
- Салбарын захирал, нягтлан бодогч нарыг томилсон шийдвэр, тэдгээрийн иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/, эсхүл тухайн орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох зохих байгууллагын тодорхойлолт;
- Салбарын захирал, нягтлан бодогч нь сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй тухай тухайн этгээдээс гаргасан тодорхойлолт.

3. Оноосон нэр өөрчлөх

- ХЗХ-ны оноосон нэрийг өөрчлөх талаар бүх гишүүд хуралдаж дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна;
- ХЗХ-ны оноосон нэрийн өөрчлөлтийг дүрэмд тусгаж, бүх гишүүдийн хурлаас баталсан байна;

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан хуулийн этгээдийн шинэ нэрийн баталгаажуулалтын хуудас;
- Оноосон нэр солих үеийн санхүүгийн тайлан, гишүүдийн хадгаламж, зээл, хувь хөрөнгө болон өр төлбөр, авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг гаргаж нягтлан бодогч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

4. Өөрчлөн байгуулах

- ХЗХ тус бүрийн тэргүүлэгчдийн зөвлөл нь өөрчлөн байгуулах шийдвэрийн төсөл болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ, шинээр байгуулагдах ХЗХ-ны дүрмийн төслийг тус бүрийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн хурлын тэмдэглэл, шийдвэрийг ирүүлнэ;
- Өөрчлөн байгуулагдах ХЗХ-ны гишүүдийн бүртгэлийг өөрчлөн байгуулагдах үеийн байдлаар үйлдэж хоршооны дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Мөн үеийн байдлаар ХЗХ-ны гишүүдийн зээл, хадгаламж, хүүгийн үлдэгдлийн тайланг гишүүн тус бүрээр гаргаж дарга, нягтлан бодогч нарын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна;
- Өөрчлөн байгуулах үеийн санхүүгийн тайланг ХЗХ тус бүр гаргаж дарга, нягтлан бодогч нарын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна;
- Өөрчлөн байгуулагдаж байгаа ХЗХ-ны өр төлбөр, өглөг, авлагын дэлгэрэнгүй бүртгэл үйлдэж, хэрхэн шийдвэрлэх тухай ХЗХ-ны шийдвэр гаргаж, авлага, өртэй холбоотой байгууллага иргэдтэй тооцоо нийлсэн баримт үйлдэх, гэрээ байгуулах зэргээр баталгаажуулсан байна;
- Өөрчлөн байгуулах үйл ажиллагаатай холбоотой удирдлага зохион байгуулалт, гарах зардлыг зориулалт, төрлөөр ангилан төсөвлөж бүх гишүүдийн хурлаар шийдвэрлүүлсэн байна;
- Нийлэх гэрээнд шинээр байгуулагдах ХЗХ-ны гишүүдийн оруулах хөрөнгө, бүх гишүүдийн хурал хуралдах хугацаа, товыг заасан байна;
- Нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсаны үр дүнд шинээр байгуулагдах ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг холбогдох журмын дагуу Хороонд гаргаж зөвшөөрөл авна.

5. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах

- ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахыг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө Хороонд ирүүлнэ;
- Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах асуудлыг хэлэлцсэн тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувийг ирүүлнэ;
- Хадгаламж, зээл, хувь хөрөнгө, гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэлийг гаргаж гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан ирүүлнэ;
- Анх олгосон тусгай зөвшөөрлийн хугацаанаас нь доошгүй хугацаагаар боловсруулсан бизнес төлөвлөгөөг зөвлөмжийн дагуу боловсруулан бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батална.

6. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлийг сэргээлгэх

- ХЗХ-ны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл түдгэлзүүлсэн хугацаанд сэргээлгэхийг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хугацаа дуусахаас өмнө Хороонд ирүүлнэ;
- ХЗХ нь зөрчил, дутагдлаа арилгаж, хэвийн үйл ажиллагаагаа хангасан тухай үүрэг даалгаврын биелэлт, нотлох баримтын хамт ирүүлнэ.

ДӨРӨВ. БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

А. Бүртгэлийн СЗХ01003 маягтыг бөглөх

Өргөдөл гаргагч ХЗХ-ны оноосон нэр болон регистрийн дугаарыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичсэний дагуу бөглөнө.

Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Хэсэг 1. Сонгуульт болон гүйцэтгэх удирдлагыг бүртгүүлэх

ХЗХ-ны сонгуульт болон гүйцэтгэх удирдлага солигдох тохиолдолд шинээр сонгогдож, томилогдсон хүний албан тушаал, овог нэр, хаяг, холбоо барих утас, регистрийн дугаарыг тодорхой бичнэ.

Хэсэг 2. Хаяг, байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх

Шинэ хаяг, байршлыг тодорхой бичих бөгөөд ХЗХ-ны дүрэм болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан байх шаардлагатай.

Б. Баримт бичгийг бүрдүүлэх

Сонгуульт болон гүйцэтгэх удирдлагыг бүртгүүлэхдээ бүртгэлийн СЗХ01003 маягтаар гаргасан өргөдөлд, "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 2 дугаар хавсралт (Ж)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана:

- Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах бол ХЗХ-ны бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ;
- Зээлийн хорооны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болон гүйцэтгэх захирал өөрчлөх бол тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11 дэх хэсэгт заасны дагуу тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн нь банк, санхүү, хуулийн мэргэжилтэйг нотлох дипломын хуулбар, эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох тодорхойлолт байвал зохино;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11 дэх хэсэгт заасны дагуу тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, ял шийтгэлгүй, тухайн сонгуульт ажлыг хашихад харшлах зүйлгүй, сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаагүй, банк, санхүү, хуулийн мэргэжилтэй, эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатай байвал зохино;
- Шинээр томилогдсон гүйцэтгэх удирдлага нь энэхүү зааврын хавсралт 1-ийн дагуу анкет бөглөж, сүүлийн жилд авхуулсан 3*4 хэмжээтэй цээж зургийг наана. Хэрэв цахимаар бөглөж байгаа тохиолдолд цээж зургийг байршуулна.


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх,
баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралт



**ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛЬТ
БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТНЫ
ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Иргэний харьяалал:	
ХЗХ-д эрхлэх сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Эрхэлж байгаа жил, албан тушаал	
Ажлын хаяг	
Цахим хаяг	



2. Боловсрол/Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 3.1.4 - д заасан "нэгдмэл сонирхолтой этгээд" гэж хадгаламж, зээлийн хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл болон зээлийн

хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтантай эд хөрөнгө, садан төрлийн зэрэг хувийн ашиг сонирхлын холбоо бүхий этгээд

№	Тантай ямар хамааралтай болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:


/..... / /..... / /..... / /..... /

/Албан тушаал/

/Овог, нэр/

/гарын үсэг/

огноо



Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан
"Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх,
баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын 2 дугаар хавсралт



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ
ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН
ЗАГВАР**

Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн нэр	
--	--

ХӨРӨНГӨ	ДҮН	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ	ДҮН
<i>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</i>		<i>НИЙТ ӨР ТӨЛБӨР</i>	
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>		<i>Богино хугацаат өр төлбөр</i>	
Бэлэн мөнгө		Дансны өглөг	
Банкинд байгаа мөнгө		Урьдчилж орсон орлого	
Дансны авлага		Бусад	
Бусад санхүүгийн хөрөнгө		<i>Урт хугацаат өр төлбөр</i>	
Урьдчилж төлсөн зардал		Хойшлогдсон татварын өр төлбөр	
Богино хугацаат хөрөнгө оруулалт		Бусад урт хугацаат өр төлбөр	
Бусад эргэлтийн хөрөнгө			
<i>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</i>		<i>ЭЗДИЙН ӨМЧ</i>	
Үндсэн хөрөнгө		<i>Хувь нийлүүлсэн хөрөнгө</i>	
Биет бус хөрөнгө		Нэмж төлөгдсөн капитал	
Урт хугацаат хөрөнгө оруулалт		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
Бусад эргэлтийн бус хөрөнгө		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	
		Тусгай зориулалтын нөөцийн сангууд	
		Хуримтлагдсан ашиг/алдагдал	
Нийт хөрөнгийн дүн		Нийт өр төлбөр ба эздийн өмч	

Захирлын нэр

Гарын үсэг

Огноо